



**МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ**

2015 оны 01 сарын 14 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

**“Улаанбаатар хотын даатгал” ХХК-д хувь нийлүүлсэн  
хөрөнгийн хэмжээндээ өөрчлөлт оруулахыг  
зөвшөөрөх тухай**

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох тухай” 355 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Улаанбаатар хотын даатгал” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тус компанийн 2013 оны хуримтлагдсан ашгаас хувьцаа эзэмшигчдэд хуваарилсан 750,000,000 /долоон зуун тавин сая/ төгрөгийн ногдол ашгийн мөнгөн хөрөнгөөр нэмэгдүүлж дараах байдлаар тогтоохыг зөвшөөрсүгэй:

№	Хувь нийлүүлэгч	Хөрөнгийн хэмжээ /төгрөгөөр/			Дүрмийн санд эзлэх хувь
		Эхний үлдэгдэл	Өөрчлөлт	Эцсийн үлдэгдэл	
1	Ц.Чинбат	2 007 500 000	547 500 000	2 555 000 000	73%
2	М.Энхболд	702 500 000	202 500 000	905 000 000	25,86%
3	Нийслэлийн Өмчийн Харилцааны Газар	40 000 000	-	40 000 000	1,14%
	Дүн	2 750 000 000,00	750 000 000,00	3 500 000 000,00	100,00%

2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн, холбогдох баримтыг 2015 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Улаанбаатар хотын даатгал” ХХК /М.Энхболд/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Энхбаяр/-нд даалгасугай.

ДАРГА



Э.НАРАНТУЯА

000619